

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ (Сонгох даалгавар)

Санамж:

1. Зохиолын хэсгийг анхааралтай уншиж ойлгоорой.
2. Асуулт даалгавар бүрийг анхааралтай, дуустал уншиж гүйцэтгээрэй.
3. Сонгож авсан үг, өгүүлбэрийг зохиолын хэсгийн утга санаатай холбож ажиглаарай.
4. Сонгох даалгавраас зөвхөн нэгийг сонгоорой. (Даалгавар бүр 2 оноотой)

Шөргөн шар атны дууль

Хөтөл элсний нарийн хоолойд нэгэн том хөх чулуу тэнгэрээс уначхаа юу гэлтэйг үзвэл чулуу бус хэвтэж байгаа тэмээ болой. Тэнгэр мөрлөж дүнхийдэг ширээ хоёр бөх нь хальс болон шалчийж унаад, бужигнасан хар ялаанд шавуулавч, түүнийг үргээх ч сөл бага болжээ. Эхэн булгийн ус шиг мэлмэн хар нүднээс нь сувдан нулимс бөн бөн бөмбөрнө. Нулимст хар нүдэнд нь тэнгэрийн хаяаны наана хөхөртөх майхан цэнхэр уул хөдөлж нэг харагдана, хөшиж нэг үзэгдэнэ. Тэр уулын ар шилд улаан бударганат их хоолой буй. Унасан шороо, ундалсан ус нь тэр билээ. Аравхан алхаад гарчих энэхүү нарийхан элсний хормойд нар тусахын алдад мөлхөж ирсэн юмсан. Мөлхөөд мөлхөөд ч газар гавьтай хорсонгүй.

...Толгойгоо дээш өргөж харвал мөнөөх уул цэнхэртэж л харагдана. Ард нь тунгалаг хүйтэн устай худаг байдаг сан. Эзэн нь гурван алдын ширэн ховоогоор гурав татахад модон онгоц мэлтгэнэн дүүрч, түүнээс тамшаалан залгилаад, уруулаасаа ус дуслуулан, бөхнийхөө ялааг шавшиж үргээгээд, урт сайхан хүзүүгээ сунгаж, эргэн тойрноо ажиг, тэнгэрийн хаяа ширтэн бодлогоширч зогсох бахтай сан... Салхи шиг явсан тэр цаг амбасын зүүд манан дунд бүрэлзэнэ.

...Шөргөн шар атны эцсийн хүсэл бол эхээс унаж, эхэлж амьсгал авсан улаан бударганат говьдоо амьд халуун цогцсынхоо сүүлчийн амьсгааг хүргэх явдал байлаа. Цаг мөч өнгөрөх тусам хамаг бие хуурайшиж, голдоо хүртэл үдээр болон хатаж буй нь мэдрэгдэх авч, тэнгэрийн хаяаны майхан цэнхэр уулыг харах бүрийд чийг мөрөөдөх биеийнх нь хаанаас гардаг юм гэмээр бөөн бөөн нулимс мэлмэн хар нүднээс нь ус шиг бөмбөрнө.

(Г.Мэнд-Ооёо)

Үгийн тайлбар: сөл-тамир тэнхээгүй болох
үдээр-хатсан, туранхай эцэнхий

1. Шөргөн шар ат хаашаа тэмүүлэн явсан бэ?
 - A. Цэнхэр уул руу
 - B. Хөтөл элсний нарийн хоолой руу
 - C. Уулын орой руу
 - D. Унасан шороо, ундалсан ус руугаа
 - E. Тэнгэрийн хаяа руу
2. Яагаад Шөргөн шар атны тухай “чийг мөрөөдөх биеийнх нь хаанаас гардаг юм гэмээр бөөн бөөн нулимс мэлмэн хар нүднээс нь ус шиг бөмбөрнө” гэж бичсэн бэ?
 - A. Бужигнасан хар ялаа шавсныг үргээх сөл байгаагүй учраас бөөн бөөн нулимс бөмбөрсөн.
 - B. Мөлхөөд мөлхөөд газар гавьтай хороогүй учраас бөөн бөөн нулимс бөмбөрсөн.
 - C. Ширээ хоёр бөх нь хальс болон шалчийж унасан учраас бөөн бөөн нулимс бөмбөрсөн.
 - D. Эх нутаг руугаа тэмүүлэх сэтгэл нь хүчтэй байсан учраас бөөн бөөн нулимс бөмбөрсөн.
 - E. Цаг мөч өнгөрөх тусам хамаг бие нь хуурайшсан учраас бөөн бөөн нулимс бөмбөрсөн.
3. Эхийн өрнөл хэсгийн утгад **хамааралгүй** үгийг сонгоорой.

| | |
|---------------------------|--------------------------|
| A. Цэнхэртэж харагдана.. | B. Шалчийж унаад... |
| C. Мэлтгэнэн дүүрч... | D. Ширтэн бодлогоширч... |
| E. Тамшаалан залгилаад... | |
4. Дүрслэх хэрэглүүр **илрээгүй** хэсгийг сонгоно уу.
 - A. Тэнгэр мөрлөж дүнхийдэг ширээ хоёр бөх...
 - B. Эхэн булгийн ус шиг мэлмэн хар нүд...
 - C. Салхи шиг явсан тэр цаг...
 - D. Майхан цэнхэр уул...
 - E. Хөхөртөх цэнхэр уул...

5. Эхийн сэдвийг тодорхойлоорой.
- A. Майхан цэнхэр уулын тухай
 - B. Эх орноороо бахархаж явах тухай
 - C. Үзэсгэлэнт сайхан байгалийн тухай
 - D. Байгаль ба амьтны хүйн холбооны тухай
 - E. Хүн байгалийн харьцааны тухай
6. “Насаа олсон нутагтаа Ясаа тавих нь жаргал” гэсэн гол санааг илэрхийлсэн хэвшмэл хэлцийн утгыг илэрхийлэх тулгуур өгүүлбэрийг олоорой.
- A. Эхээс унаж, эхэлж амьсгал авсан улаан бударганат говьдоо амьд халуун цогцсынхоо сүүлчийн амьсгааг хүргэх явдал байлаа.
 - B. Аравхан алхаад гарчих энэхүү нарийхан элсний хормойд нар тусахын алдад мөлхөж ирсэн юмсан.
 - C. Майхан цэнхэр уулыг харах бүрийд чийг мөрөөдөх биеийнх нь хаанаас гардаг юм гэмээр бөөн бөөн нулимс мэлмэн хар нүднээс нь ус шиг бөмбөрнө.
 - D. Нулимст хар нүдэнд нь тэнгэрийн хаяаны наана хөхөртөх майхан цэнхэр уул хөдөлж нэг харагдана, хөшиж нэг үзэгдэнэ.
 - E. Хөтөл элсний нарийн хоолойд нэгэн том хөх чулуу тэнгэрээс уначхаа юу гэлтэйг үзвэл чулуу бус хэвтэж байгаа тэмээ болой.
7. “Улаан бударганат говьдоо амьд халуун цогцсынхоо сүүлчийн амьсгааг хүргэх явдал байлаа” гэж бичсэнээр зохиолч юуг хэлэхийг хүссэн бэ?
- A. Алив амьтан төрсөн нутагтайгаа хүйн холбоотой байдаг гэдгийг хэлэхийг зорьсон.
 - B. Төрсөн нутагтаа амьд мэнд очих нь чухал гэдгийг хэлэхийг зорьсон.
 - C. Нутагтаа очих нь сайхан байдаг гэдгийг хэлэхийг зорьсон.
 - D. Улаан бударганат говьдоо очих нь чухал юм гэдгийг хэлэхийг зорьсон.
 - E. Эх нутагтаа ясаа тавьдаг гэдгийг хэлэхийг зорьсон.
8. “Уруулаасаа ус дуслуулан бөхнийхөө ялааг шавшиж үргээгээд, урт сайхан хүзүүгээ сунгаж, эргэн тойрноо ажин, тэнгэрийн хаяа ширтэн бодлогоширч зогсох бахтай сан...” өгүүлбэрт сэтгэлийн ямар өнгө аяс илэрсэн бэ?
- A. Уйтгарласан өнгө аяс
 - B. Хүсэмжилсэн өнгө аяс
 - C. Шаналсан өнгө аяс
 - D. Харууссан өнгө аяс
 - E. Бадрангуй өнгө аяс
9. Эхийн хэв маягийг зөв тодорхойлсныг олоорой.
- A. Тайлбарласан эх
 - B. Тоочсон эх
 - C. Хүүрнэсэн эх
 - D. Эргэцүүлсэн эх
 - E. Тоочиж, тайлбарласан эх
10. “Тэнгэр мөрлөж дүнхийдэг ширээ хоёр бөх нь хальс болон шалчийжээ” гэсэн өгүүлбэрээс гурван бүрэлдэхүүнт цөм бүтцийг олоорой.
- A. Бөх нь шалчийжээ.
 - B. Ширээ хоёр бөх нь дүнхийнэ.
 - C. Тэнгэр мөрлөнө.
 - D. Хальс болон шалчийжээ.
 - E. Хоёр бөх нь хальс болжээ.
11. Эхийн дүрийн үйлээс зүйлчилсэн утгаараа ялгаатай өгүүлбэрийг олоорой.
- A. Тамшаалан
 - B. Ялааг үргээх
 - C. Онгоц дүүргэх
 - D. Аравхан алхах
 - E. Уруулаасаа ус дуслуулах
12. “Майхан цэнхэр уулыг харах **бүрийд** чийг мөрөөдөх биеийнх нь хаанаас гардаг юм гэмээр бөөн бөөн нулимс мэлмэн хар нүднээс нь ус шиг бөмбөрнө” гэсэн өгүүлбэрийн онцолсон холбоосыг тохирох үгээр солин найруулаарай.
- A. агаад
 - B. ялдамд
 - C. болгонд
 - D. тул
 - E. атал

13. “Шөргөн шар атны эцсийн хүсэл бол улаан бударганат говьдоо сүүлчийн амьсгааг хүргэх явдал байлаа” гэсэн өгүүлбэрийг салаалан хувиргасныг олоорой.
- A. Шөргөн шар атны эцсийн хүсэл бол сүүлчийн амьсгааг хүргэх явдал байлаа.
 B. Улаан бударганат говьдоо сүүлчийн амьсгааг хүргэх явдал бол шөргөн шөр атны эцсийн хүсэл байлаа.
 C. Шөргөн шар атны чин хүсэл бол улаан бударганат говьдоо ясаа тавих явдал байлаа.
 D. Шөргөн шар атны эцсийн хүсэл бол улаан бударганат говьдоо сүүлчийн амьсгааг хүргэх явдал байлаа.
 E. Шөргөн шар атны эцсийн хүсэл бол майхан цэнхэр уулын ар шил улаан бударганат говьдоо сүүлчийн амьсгааг хүргэх явдал байлаа.
14. Найруулгын алдаатай өгүүлбэрийг олоорой.
- A. Сэрүүн салхи үе үе үлээх боловч дулаан бөгөөд ер бусын тайван, аятай ажээ.
 B. Суман дэлтэй өндөр зээрд морь унасан Эрдэнэ эмээл дээрээ ялимгвй хэлтгий сууж, ямар нэгэн гүн бодолд дарагдана.
 C. Саяхан хүүхдүүд байсан, одоо ингээд л гэрлэх болж байдаг. Цаг ч мөн хурдан юм даа гээд Итгэлт өөрөө цай хийж уув.
 D. Өөдөөс харан сууж байгаа хүүхнийг зориуд ичээж, чанга чанга ширтэж байв.
 E. Чи битгий надад гомдоорой, би ч чамд тэр нэгэн цагт хязгааргүй сэтгэлтэй байсан минь үнэн.
15. “Эхэн булгийн ус шиг мэлмэн хар нүднээс нь сувдан нулимс бөн бөн бөмбөрнө” гэсэн өгүүлбэрийн байц гишүүнийг олоорой.
- A. ус шиг
 B. эхэн булгийн
 C. бөн бөн
 D. сувдан
 E. бөмбөрнө
16. “Цаг мөч **өнгөрөх тусам** хамаг бие хуурайшна” гэсэн өгүүлбэрийн онцолсон өгүүлэхүүнийг яаж хувиргавал шалтгааны байц гишүүн өгүүлбэртэй угсарсан нийлмэл өгүүлбэр болох вэ?
- A. өнгөрвөл
 B. өнгөрдөг
 C. өнгөрснөөс болж
 D. өнгөрөх агаад
 E. өнгөрөх нь
17. “Ширэн ховоогоор гурав татахад модон онгоц дүүрнэ” гэсэн өгүүлбэрийн хэв шинжийг тодорхойлоорой.
- A. Угсарсан нийлмэл өгүүлбэр
 B. Харилцан угсарсан нийлмэл өгүүлбэр
 C. Энгийн өгүүлбэр
 D. Зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр
 E. Холимог нийлмэл өгүүлбэр
18. Дараах холбоо үгийн бүтцийг ажиглаад, цэгийн оронд тохирох үгийг олоорой.
 Нулимс бөмбөрөх, ус залгилах, уул харагдах, түүнийг үргээх
- A. ялаанд шавуулах
 B. хүзүүгээ сунгах
 C. чийг мөрөөдөх
 D. газар хорох
 E. манан дунд бүрэлзэх
19. “Тэнгэрийн хаяа” гэсэн холбоо үгийн харьяалахын тийн ялгалын нөхцөлийн утга нь аль вэ?
- A. Уул юм хэний, юуны эзэмшилд буй утга
 B. Орших байр, орон зай заасан утга
 C. Бүхлийн хэсгийг заасан утга
 D. Тоо ширхэг, хэмжээ заасан утга
 E. Шинж чанар заасан утга
20. Дараах холбоо үгийг ажиглаад, шууд утгаараа байгаа үгийг олоорой.
- A. аравхан алхаад гарчих газар
 B. арав тавхан төгрөг
 C. адаг муу арав хувилах
 D. адгийн зарга арав хоногтой
 E. арав арваар жагсах
21. Ойролцоо утгатай үгсийг олоорой.
- A. дээр доор
 B. гарах буух
 C. өөд уруу
 D. хөөх элдэх
 E. авирах буух

22. Эс тусах, үүсмэл, өөрөө үйлдэх хэв, энгийн үйлдэх, зэрэгцэн холбохын нөхцөлтэй үйл үгийг олоорой.
 А. хуурайшиж В. мөрөөдөх С. шавшдаг
 D. үргээх E. харагдаж
23. Үгийн бүтцээр зөв задалсныг олоорой.
 А. хүзүү+0+г+ээ В. мэл+тэг+нэн С. дүнх+ий+0+0+дэг
 D. уруул+аас+аа E. цэнхэр+т+0+ж
24. “Хууль дүрмийг нарийн судлаж хэрэгжүүлэе. Бид замаас гажаж явлаа. Нугас зургаан ангаахайгаа дагуулан ертөнцтэй танилцуулахаар замын хажуугын хог өвсөн дунд орход тэд хөөцөлдөв” гэсэн өгүүлбэрүүдэд зөв бичгийн дүрмийн алдаатай үг хэд байна вэ?
 А. 7 В. 3 С. 5 D. 4 E. 6
25. Дараах үгээс төрөл биш утгатай үгийг олоорой.
 А. мэлтий В. мэлз С. мэлтгэнэ D. мэлтгэр E. мэлтэлз
26. Үгсийн аймгаар зөв бүлэглэсэн нь аль вэ?
 А. элсний, нэгэн, тэмээ, ялаанд В. нарийхан, том, түүнээс, шилд
 С. тэр, мөнөөх, тусам, дээш D. урт, нарийхан, мэлмэн, сувдан
 E. дүнхийдэг, хормойд, толгойгоо, алдад
27. Гурван үет бүлэг үгс нь аль вэ?
 А. тэнгэрээс, дүнхийдэг, бужигнасан, хөхөртөх, ундалсан
 В. харагдах, бөмбөрнө, хуурайшиж, амбасын, үргээгээд
 С. мэлтгэнэн, тамшаалан, уруулаасаа, бодлогоширч, бахтай сан
 D. татахад, залгилаад, бөхнийхөө, шавшиж, амьсгал
 E. биеийнх, тусахын, цэнхэртэж, тунгалаг, дүүрч
28. Утга төгс өгүүлбэр бүтээхэд цэгийн оронд аль бүтээврүүд дарааллаараа тохирох вэ?
 “Хяруу уна..., гол зайрмаг...сан бол...сөл тасраагүй байна.”
 А. -аад,-д,-вч В. -саар,-т,-оод С. -х,-л,-вч D. -ж,-т,-вч E. -магц,-т,-тол
29. Үйлээс нэр үг үүсгэх “-лт” дагаврыг **хамгийн оновчтой** найруулсан жишээг олоорой.
 А. Багш самбарт бодолт хийв. В. Хүүхдүүд амжилт гаргалаа.
 С. Уурхайчид ажил хаялт хийв. D. Сурагчдын гэрчилгээний бичилт хийлээ.
 E. Ажлын үр дүнд дүгнэлт гаргав.
30. Олон тооны дагаврыг зөв хэрэглэснийг олоорой.
 А. атга элсэн чихэр В. од мичдүүд
 С. олон хүүхдүүд D. голын уснууд
 E. хоолны савхнууд
31. Найруулгын дээд, дунд, доод зэргээр **илрээгүй** бүлэг үгийг олоорой.
 А. мишээх, инээх, инээмсэглэх В. нойрсох, унтах, дугжрах
 С. эрвээлж, эмээл, янгиа D. мэлмий, нүд, циймэр
 E. сэвлэг, үс, хялгас
32. Хурлын тэмдэглэлийн бүтцэд **хамааралгүй** үгийг сонгоорой.
 А. Байгууллагын нэр
 В. Хэлэлцэх асуудал
 С. Баримт бичгийн гарчиг
 D. ...оршин суудаг нь үнэн болно.
 E. Хуралдсан он, сар, өдөр

33. “Булаг шанд” гэсэн холбоо үгийн зөв бичсэнийг олоорой.

- A B|ᠠᠭᠣ
- B B|ᠠᠭᠢ
- C B|ᠠᠭᠢᠲ
- D B|ᠠᠭᠣᠲ
- E B|ᠠᠭᠢᠲ

34. Холбох эгшгийн дүрмээр бичсэн үгийг олоорой.

- A Bᠠᠳᠠᠪᠠᠭ
- B Bᠠᠭᠢᠵᠢᠨ
- C Bᠠᠳᠠᠰᠠᠭ
- D Bᠠᠳᠠᠳᠠᠭᠢᠲ
- E Bᠠᠳᠠᠪᠠᠭᠠᠭ

35. Цэгийн оронд тохирох дагаврыг нөхөж, зүйр цэцэн үг бүтээгээрэй.

- A Bᠠᠳᠠᠳᠠᠭᠢᠲ
- B Bᠠᠳᠠᠳᠠᠭᠢᠲ
- C Bᠠᠳᠠᠳᠠᠭᠢᠲ
- D Bᠠᠳᠠᠳᠠᠭᠢᠲ
- E Bᠠᠳᠠᠳᠠᠭᠢᠲ

36. Монгол бичгээр бичсэн эхийг зөв хөрвүүлснийг олоорой.

- | | | | | |
|---|---|---|---|---|
| A Bᠠᠳᠠᠳᠠᠭᠢᠲ C D E | A B C D E | A B C D E | A B C D E | A B C D E |
| Bᠠᠳᠠᠳᠠᠭᠢᠲ Bᠠᠳᠠᠳᠠᠭᠢᠲ Bᠠᠳᠠᠳᠠᠭᠢᠲ Bᠠᠳᠠᠳᠠᠭᠢᠲ Bᠠᠳᠠᠳᠠᠭᠢᠲ | Bᠠᠳᠠᠳᠠᠭᠢᠲ Bᠠᠳᠠᠳᠠᠭᠢᠲ Bᠠᠳᠠᠳᠠᠭᠢᠲ Bᠠᠳᠠᠳᠠᠭᠢᠲ Bᠠᠳᠠᠳᠠᠭᠢᠲ | Bᠠᠳᠠᠳᠠᠭᠢᠲ Bᠠᠳᠠᠳᠠᠭᠢᠲ Bᠠᠳᠠᠳᠠᠭᠢᠲ Bᠠᠳᠠᠳᠠᠭᠢᠲ Bᠠᠳᠠᠳᠠᠭᠢᠲ | Bᠠᠳᠠᠳᠠᠭᠢᠲ Bᠠᠳᠠᠳᠠᠭᠢᠲ Bᠠᠳᠠᠳᠠᠭᠢᠲ Bᠠᠳᠠᠳᠠᠭᠢᠲ Bᠠᠳᠠᠳᠠᠭᠢᠲ | Bᠠᠳᠠᠳᠠᠭᠢᠲ Bᠠᠳᠠᠳᠠᠭᠢᠲ Bᠠᠳᠠᠳᠠᠭᠢᠲ Bᠠᠳᠠᠳᠠᠭᠢᠲ Bᠠᠳᠠᠳᠠᠭᠢᠲ |

37. “Малын толгой дээшээ
Өвчний толгой доошоо

Эм дом, эм дом” гэсэн нь аман зохиолын ямар төрөл вэ?

- A. Ертөнцийн гурав
- B. Ерөөл
- C. Мянгалын үг
- D. Дом шившлэг
- E. Зүйр үг

38. Д.Равжаагийн “Ичиг, ичиг” шүлгийн орхигдсон хэсгийг нөхөөрэй.

“Аяа бас, сэтгэлээ зассангүй залуучууд ичиг”

- A. хэрэлдэгч
- B. санаашрагч
- C. гангалагч
- D. хов зөөгч
- E. элдвийг сурагч

39. Шүлэг бичиж суухад хаалга онголзуулж болохгүй

Шүлэг гэдэг шувуу үүдээр гараад нисчихнэ

Нэгэнтээ тэр одвол

Нэхэж хөөгөөд гүйцэхгүй

Эрвээхий наадах нугад

Эрдэнийн солонго шиг шингэнэ.(Д.Нямсүрэн)

Шүлгийн тодруулсан мөрд ямар дүрслэх хэрэглүүр илэрсэн бэ?

- A. Тойруулал
- B. Хэтрүүлэл
- C. Багасгал
- D. Зүйрлэл
- E. Ихэсгэл

40. Ишданзанванжилын “Гүнгийн зуугийн гэгээний Алтан сургаал”-аас үр хүүхдээ зөв хүн болгохын тулд сургаж хэлсэн утгатай хэсгийг олж тэмдэглэнэ үү.
- A. Унтахыг хэмнэвээс сэргэг хөнгөн болно.
Ундааныг хэмнэвээс судал чанга болно.
 - B. Ширээнд залахуйд гэгээн багшийн дүртэй
Шилдэг морь унахуйд маймаа панзын маягтай
 - C. Гадаад Монгол төрийн үнэн цагаан боолыг
Ганц биеийн өмч мэт эндүүрэх
 - D. Аав ээжийн ач хүчин их байтал
Адлах, муулах, зүхэх нь олон буй.
 - E. Үрийн бие өвдвөл их ихэс зовнин
Үтэртусыг эгээрч лам эмч урьмуй.

ХОЁРДУГААР ХЭСЭГ (Харгалзуулах даалгавар)

Санамж:

1. Энэ хэсэг сонгох даалгавар биш тул харгалзааг зөв тогтоож, хариуг бөглөөрэй.
2. Зөв харгалзуулсан хариулт бүр 1 оноотой.

2.1 Хэлцийг ойролцоо утгаар нь зөв харгалзуулаарай.

- | | |
|-------------------------------|-------------------------|
| a. Гараас гарах | 1. Шил нь татах |
| b. Барилдахаасаа таахалзах нь | 2. Бие даах |
| c. Гэдэн хөдлөх | 3. Бөөсөнд хутга гаргах |
| d. Үрэн таран хийх | 4. Гол орох |
| e. Өвчүүний цаагуур юм шидэх | 5. Гараа угаах |

2.2 Зохиолын өгүүлэгдэхүүний бүрдэл хэсгүүдийн тодорхойлолтыг зөв хариутай нь харгалзуулаарай.

- | | |
|-------------|---|
| a. Төгсгөл | 1. Зохиолын эхлэл хэсгийг залган хөгжүүлж, улмаар зөрчил үүсгэн, үйл явдлын цаашдын өрнөх шалтгаан болж буй хэсэг |
| b. Эхлэл | 2. Зохиолын үйл явдал, зөрчил тэмцэл алгуур хөгжсөөр цаашид үргэлжлэх аргагүй болтлоо хурцдаж, дээд цэгтээ хүрсэн хэсэг |
| c. Зангилаа | 3. Өгүүлэгдэхүүний өрнөх дэвсгэр суурь бөгөөд цаашид зохиолын зөрчил, тэмцэл гарах ахуй амьдрал, нийгмийн нөхцөл, гол баатруудын тухай танилцуулдаг хэсэг |
| d. Туйл | 4. Зохиолчийн өөрийн үнэлэмж, хандлага, дүгнэлт бүхий хэсэг |
| e. Өрнөл | 5. Зангилаа бий болсноос хойш тэрхүү эгзэгтэй зангилааны учир зүйг олохын тулд чөлөөтэй өрнөж буй хэсэг |

2.3 Үгийг утгын тайлбартай нь зөв харгалзуулаарай.

- | | |
|--------------------|--|
| a. шиврээ бороо | 1. гэнэт ихээр орсон, түр зуурын асгасан мэт бороо |
| b. хөөсөрхөг бороо | 2. зун цагийн шимт шингэц сайтай найртай хур |
| c. асгал бороо | 3. бороо орох мэт болж сандаргаад холуур өнгөрөх бороо |
| d. эрвээхий хур | 4. алгуур зөөлөн орох бороо |
| e. залир бороо | 5. түрүүлж буусан хур газарт шингэлгүй дараагийн бороо нь хийтэн цэврүүтэн хөөсөрхөг болох бороо |

2.4 Зөвийг нь олж харгалзуулаарай.

| | | 1 | 2 | 3 | 4 | 5 |
|----|--|------------|----------|-----------|-----------|-----------|
| a. | Бүрмөсөн үйлдэх байдлын “-чих” дагавартай үгийг буруу бичсэн үг | тоглочихыг | одчхоод | явчхуузай | авчихаар | өгчхөөсэй |
| b. | “-ийг” нөхцөлийг бичих үг | навч | хана | арвин | олз | сахилга |
| c. | Гийгүүлэгчээр төгссөн үгэнд үйл үг бүтээх “-л” дагаврыг залгахад балархай эгшгийг хойно нь бичих үг | цонх+л | борц+л | алд+л | хэрэг+л | цоож+л |
| d. | Гийгүүлэгчээр төгссөн үгэнд урт эгшгээр эхэлсэн залгавар залгахад эцсийнгийгүүлэгчийн өмнөх балархай эгшиг гээгдэхгүй үг | хөгжил+ийг | хавар+ын | улам+аас | барил+аар | журам+ыг |
| e. | Зөөлний тэмдэг “и” болохгүй үг | тавь+в | захь+сан | барь+мт | холь+могц | тахь+лаа |